

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/26/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитор: Н.Бадамханд  
Утас: 99042699 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.6.3 Нэмэлт төсөв.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	14
5.1 Төлбөрийн акт .....	14
5.2 Албан шаардлага.....	14
5.3 Зөвлөмж .....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	15

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

\_\_\_\_\_ № \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА Ж.ДАВААДАМДИН  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нүүдэлчин монгол наадмын шилдэг отог урамшуулал 95.0 төгрөгийн авсан. Үүнээс оролцогчийн урамшуулалд 20.0 сая төгрөг нэг удаагийн шагнал урамшуулал дээр эрх нээлгэж зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Харьцуулалтын аргаар зарласан тендерийн худалдан авалтын үнэ зах зээлийн үнээс харьцангуй өндөр байна гэж харлаа.

### Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 2 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 88.4 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15,966,900.00</u></b>	<b><u>4,597,900.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	15,000,000.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,000,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	966,900.00	4,597,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	966,900.00	4,597,900.00
35410	Бичиг хэргийн материал	230,000.00	1,435,000.00
35420	Аж ахуйн материал	736,900.00	3,162,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>8,506,101.00</u></b>	<b><u>93,995,181.43</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,506,101.00	93,995,181.43
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	8,506,101.00	92,713,931.43
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,374,800.00	81,327,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,708,247.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,131,301.00	19,631,301.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,536,522.23)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	1,281,250.00
39301	Программ хангамж	-	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(218,750.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>24,473,001.00</u></b>	<b><u>98,593,081.43</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>24,473,001.00</u></b>	<b><u>98,593,081.43</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	24,473,001.00	98,593,081.43
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	24,473,001.00	98,593,081.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-	24,473,001.00
51220	Тайлант үеийн үр дүн	24,473,001.00	74,120,080.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>24,473,001.00</u></b>	<b><u>98,593,081.43</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>44,571,201.00</b>	<b>436,233,940.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,071,201.00</b>	<b>25,367,600.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,071,201.00	25,367,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,071,201.00	25,367,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,071,201.00	25,367,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>37,500,000.00</b>	<b>410,866,340.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	210,832,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	210,832,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	22,500,000.00	182,033,840.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	32,083,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,500,000.00	149,950,000.00

Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын тайлан

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	15,000,000.00	18,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,000,000.00	18,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,098,200.00</b>	<b>362,113,859.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>20,098,200.00</b>	<b>362,113,859.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	19,480,949.37	315,915,668.11
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	9,503,921.44	142,098,840.78
210101	Үндсэн цалин	7,929,701.07	83,635,425.42
210102	Нэмэгдэл	1,574,220.37	16,269,503.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,873,496.74
210104	Урамшуулал	-	22,320,415.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	758,627.93	17,762,357.04
210201	Тэтгэврийн даатгал	517,396.25	12,078,403.09
210202	Тэтгэмжийн даатгал	60,870.14	1,420,988.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	48,696.10	1,136,790.69
210204	Ажилгүйдлийн даатгал	9,925.17	284,197.84
210205	Эрүүл мэндийн даатгал	121,740.27	2,841,976.88
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,073,700.00	34,793,869.72
210401	Бичиг хэрэг	693,280.00	2,314,050.00
210402	Тээвэр, шатахуун	4,016,500.00	13,674,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,190,269.72
210404	Ном, хэвлэл	-	16,250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	14,051.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	363,920.00	1,350,999.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1,232,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	170,000.00
210604	Урсгал засвар	-	1,062,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,390,500.00	-
210702	Дотоод албан томилолт	2,390,500.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	88,649,681.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	88,649,681.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,754,200.00	31,378,919.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	254,200.00	22,915,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	8,463,519.57
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	617,250.63	46,198,191.46
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	21,886,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	21,886,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	617,250.63	24,312,191.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	617,250.63	24,312,191.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>24,473,001.00</b>	<b>74,120,080.43</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>24,473,001.00</b>	<b>74,120,080.43</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	24,473,001.00	24,473,001.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	24,473,001.00	24,473,001.00
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	24,473,001.00	24,473,001.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	24,473,001.00	24,473,001.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	74,120,080.43	74,120,080.43
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	98,593,081.43	98,593,081.43

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>37,500,000.00</b>	<b>425,866,340.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>37,500,000.00</b>	<b>425,866,340.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	210,832,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	210,832,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	22,500,000.00	197,033,840.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	32,083,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,500,000.00	164,950,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	15,000,000.00	18,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,000,000.00	18,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>36,065,100.00</b>	<b>357,056,340.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>36,065,100.00</b>	<b>357,056,340.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>20,447,849.37</b>	<b>310,858,148.54</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	9,503,921.44	142,098,840.78
210101	Үндсэн цалин	7,929,701.07	83,635,425.42
210102	Нэмэгдэл	1,574,220.37	16,269,503.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	19,873,496.74
210104	Урамшуулал	-	22,320,415.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	758,627.93	17,762,357.04
210201	Тэтгэврийн даатгал	517,396.25	12,078,403.09
210202	Тэтгэмжийн даатгал	60,870.14	1,420,988.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	48,696.10	1,136,790.69
210204	Ажилгүйдлийн даатгал	9,925.17	284,197.84
210205	Эрүүл мэндийн даатгал	121,740.27	2,841,976.88
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,416,500.00	34,613,069.72

Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн  
тайлангийн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	400,000.00	2,169,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,016,500.00	13,674,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,190,269.72
210404	Ном, хэвлэл	-	16,250,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	144,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,184,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	3,170,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	170,000.00
210604	Урсгал засвар	-	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,390,500.00	-
210702	Дотоод албан томилолт	2,390,500.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	89,500,481.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	89,500,481.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,378,300.00	23,713,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,878,300.00	23,713,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,617,250.63</b>	<b>46,198,191.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	21,886,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	21,886,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15,617,250.63	24,312,191.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,617,250.63	24,312,191.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,434,900.00</u></b>	<b><u>68,810,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,434,900.00</b>	<b>68,810,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,434,900.00</b>	<b>68,810,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,434,900.00</b>	<b>68,810,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,434,900.00	68,810,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,434,900.00)</u></b>	<b><u>(68,810,000.00)</u></b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	228,832,500.00	204,520,308.54	-24,312,191.46	89.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213,832,500.00	189,520,308.54	-24,312,191.46	88.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213,446,500.00	189,134,308.54	-24,312,191.46	88.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,736,800.00	142,098,840.78	-19,637,959.22	87.86
210101	Үндсэн цалин	101,036,800.00	83,635,425.42	-17,401,374.58	82.78
210102	Нэмэгдэл	16,950,000.00	16,269,503.18	-680,496.82	95.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,550,000.00	19,873,496.74	-676,503.26	96.71
210104	Урамшуулал	23,200,000.00	22,320,415.44	-879,584.56	96.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,092,100.00	17,762,357.04	-3,329,742.96	84.21
210201	Тэтгэврийн даатгал	14,342,600.00	12,078,403.09	-2,264,196.91	84.21
210202	Тэтгэмжийн даатгал	1,687,400.00	1,420,988.54	-266,411.46	84.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,349,900.00	1,136,790.69	-213,109.31	84.21
210204	Ажилгүйдлийн даатгал	337,500.00	284,197.84	-53,302.16	84.21
210205	Эрүүл мэндийн даатгал	3,374,700.00	2,841,976.88	-532,723.12	84.21
2104	Хангамж, бараа материалын зардал	10,064,500.00	8,724,569.72	-1,339,930.28	86.69
210401	Бичиг хэрэг	2,169,000.00	2,169,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,036,000.00	4,036,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530,200.00	1,190,269.72	-1,339,930.28	47.04
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,500.00	144,500.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,184,800.00	1,184,800.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,539,700.00	13,535,141.00	-4,559.00	99.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,539,700.00	13,535,141.00	-4,559.00	99.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,013,400.00	4,013,400.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,013,400.00	4,013,400.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	386,000.00	386,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	386,000.00	386,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	386,000.00	386,000.00	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.00
223001	Бусад хөрөнгө	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	228,832,500.00	204,520,308.54	-24,312,191.46	89.38
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	228,832,500.00	204,520,308.54	-24,312,191.46	89.38
122005	Орон нутгийн төсвөөс	228,832,500.00	204,520,308.54	-24,312,191.46	89.38

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>197,033,840.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>197,033,840.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	175,533,840.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,888,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,638,500.00
210404	Ном, хэвлэл	16,250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	53,980,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,980,000.00
210602	Тавилга	5,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	75,965,340.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,965,340.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,700,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	21,500,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	21,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,500,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	197,033,840.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	197,033,840.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,083,840.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	164,950,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Соёл урлагийн газар нь Соёлын талаар баримталж буй бодлогыг орон нутгийн хөгжлийн ойрын болон хэтийн төлөвтэй уялдуулах, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын стратегийн бодлоготой нийцүүлэн аймгийн соёл урлагийн стратегийг боловсруулах, Орон нутгийн соёлын онцлог, өв соёлд тулгуурласан аймгийн соёлын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.

2.Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.

3.Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл, урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	15.0	0	-15.0
Бараа материал	0.9	4.6	3.7

Биет хөрөнгө	8.5	92.7	84.2
Биет бус хөрөнгө	0	1.2	1.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>24.4</b>	<b>98.5</b>	<b>74.1</b>
<b>Өмч</b>	<b>24.5</b>	<b>98.6</b>	<b>74.1</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>24.4</b>	<b>98.5</b>	<b>74.1</b>

Бараа материал 3.7 сая төгрөгөөр өссөн байна. Соёлын өвийн бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, хадгалалт, хамгаалалт, түгээн дэлгэрүүлэлтийг сайжруулах зорилгоор бараа материалыг бэлтгэсэн.

Үндсэн хөрөнгө данс 85.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: Нүүдэлчин Монгол наадмын шилдэг отгийн шагнал урамшууллаар сангийн сайдын 74 дүгээр тушаалын дагуу шаардлагатай тоног төхөөрөмж авах даргын тушаалаар нийт 68.8 сая төгрөгийн худалдан авалт хийж бэлдсэн нь нөлөөлсөн байна. Улсын баяр наадам аймгийн ойн арга хэмжээн хүрээнд аймгийн засаг даргын захирамжаар 19.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн.

Хуримтлагдсан үр дүн 74.1 сая төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 онд 09-р сарын 02-ны өдрийн аймгийн засаг даргын захирамжаар Соёлын хэлтэс байгуулагдан 2022 оны төсөвт 228.2 сая төгрөг батлагдсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Улсын төсвийн санхүүжилтээр 204.5 сая төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд гүйцэтгэл 204.5 сая төгрөг буюу 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/сая төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71702</b>	<b>Соёл, урлагийн газар</b>	<b>228.8</b>	<b>204.5</b>	<b>(23.4)</b>	<b>89.3</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	213.4	189.1	(24.3)	88.6
80227	Хөрөнгийн зардал	15.0	15.0	-	100.0
80802	Урсгал шилжүүлэг	0.4	0.4	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 197.0 сая төгрөг Аймгийн засаг даргын 2022 оны 3-р сарын 10-ны өдрийн А/72 дугаар захирамжаар 15.0 сая төгрөгийг багаж техник хэрэгсэл зардлаар нээлгэн техник хэрэгсэл авсан. Аймгийн засаг даргын А/211 захирамжийн дагуу баяр наадмын бэлтгэл ажлын зардал 30.0 сая төгрөгийг 19.5 сая төгрөг багаж техник хэрэгсэл дээр эрх нээлгэн хөгжим хэрэгсэл авсан бол 10.5 сая төгрөг баяр наадмын үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Аймгийн засаг даргын А/214 тушаалын дагуу Нүүдэлчин Монгол-2022 наадамд оролцох зардал 20.0 сая төгрөг Нүүдэлчин монгол наадамд оролцох үйл ажиллагааны зардалд гэрээ байгуулан зарцуулсан. Нүүдэлчин монгол наадмын шилдэг отог урамшуулал 95.0 сая төгрөг бусад нийтлэг 44.5 сая төгрөг эрх нээлгэн Оролцогчийн урамшуулалд 20.0 сая төгрөг нэг

удаагийн шагнал урамшуулал дээр эрх нээлгэж, 11.0 сая төгрөг бараа үйлчилгээний бусад зардал дээр эрх нээлгэн Хугаашан хүүхдийн жүжиг хийлгэх зардал гэрээ байгуулан олгосон. Байгууллагын шаардлагатай тоног төхөөрөмж авах нэн хэрэгцээтэй байсан тул тавилга 5.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 14.5 сая төгрөгийг эрх нээлгэн худалдан авалт хийсэн.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 3.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

###### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж, Шилэн дансны цахим хуудсанд 127.6 сая төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-ийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх

#### 4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд шалгасан нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн асуудал холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Соёл урлагийн газарт 2022 онд Завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын бүртгэлээр Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолыг зөрчсөн, томилолтын зардлыг анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн зэрэгт зөвлөмжийг өгч, тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	3.5	2	3.5	100
Нийт дүн	2	3.5	2	3.5	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 40.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, дахин давтахгүй байх 2 зөвлөмж хүргүүлсэн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

#### 5.3 Зөвлөмж

##### 1. Бараа материалтай холбоотой гүйлгээ

###### 1.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдлийн шаардлага хангахгүй баримтаар 20.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн. Өөрөөр хэлбэл шатахууныг зөвхөн шаардахаар олгож, замын тооцооны хуудсан дээр бичиж тооцоо бодохгүй олгож байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн, 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн ба "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах.

**2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 19.8 сая төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Шатахуун зарцуулалтын тооцоог хийгээгүй, үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй, шаардахаар бензин олгоод шууд замын хуудсыг санхүүгийн баримтад хавсаргасан	1	20.4					1	20.4					
И баримтаар илүү, дутуу шивэгдсэн гүйлгээнүүд байна	1	19.8					1	19.8					
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>40.2</b>					<b>2</b>	<b>40.2</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээлээгүй	3	127.6					1	127.6	

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ЧАНАРЫН ХЯНАЛТ, АХЛАХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД: